

БАТЛАВ.
БОЛОВСРОЛ ШИНЖЛЭХ УХААНЫ
ЯАМНЫ ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА Л.ЦЭДЭВСҮРЭН



2023 оны 10 дугаар сарын 27-ны өдөр

ДЭЭД БОЛОВСРОЛЫН МЭРГЭЖЛИЙН ЧИГЛЭЛ(ХӨТӨЛБӨР)-ИЙН НЭР,
ИНДЕКСИЙГ 1990 ОНООС ХОЙШ ХЭРЭГЖИЖ БАЙСАН МЭРГЭЖЛИЙН
ЧИГЛЭЛ(ХӨТӨЛБӨР)-ИЙН НЭР, ИНДЕКСТЭЙ ДҮЙЦҮҮЛЭХ, ЛАВЛАГААНЫ
САН ҮҮСГЭХ ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЖЛЫН ДААЛГАВАР

Зөвлөх үйлчилгээний нэр: Дээд боловсролын мэргэжлийн чиглэл(хөтөлбөр)-ийн нэр, индексийг 1990 оноос хойш хэрэгжиж байсан мэргэжлийн чиглэл(хөтөлбөр)-ийн нэр, индекстэй дүйцүүлэх, лавлагааны сан үүсгэх.

Гэрээний төрөл: Хуулийн этгээд

Хэрэгжүүлэх байгууллага: Боловсрол, шинжлэх ухааны яам

Даалгаврын хугацаа: 2 сар

Сонирхсон этгээд мэдүүлгээ 2023 оны 11-р сарын 25 -ны өдрийн 17 цаг 00 минутын дотор ирүүлнэ үү.

Монгол, Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, Бага тойруу-44, Засгийн газрын III байр,
Утас: 51 - 262227, Факс: +976-323158

Имэйл хаяг: letter@mecs.gov.mn

Веб сайт: <https://www.meds.gov.mn>

1. ХЭРЭГЖҮҮЛЭХ ШААРДЛАГА, ҮНДЭСЛЭЛ:

Монгол Улсын дээд боловсролын салбарт 1990 оноос хойш дээд боловсролын байгууллагуудад хэрэгжүүлэх сургалтын хөтөлбөрийн жагсаалтыг Боловсролын асуудал эрхэлсэн сайдын тушаалаар батлан хэрэгжүүлж ирсэн.

2013 онд ЮНЕСКО-оос баталсан боловсролын олон улсын стандарт ангилал(ISCED-F 2013)-ын хүрээнд дээд боловсролын салбарт хэрэгжүүлэх хөтөлбөрийн нэр, индексийн хувьд томоохон өөрчлөлт орсон бөгөөд 2014 оноос 2022 оны хооронд дээд боловсролын салбарт хэрэгжүүлэх хөтөлбөрийн нэр, индекс батлах тухай 13 тушаал гарсан байна.

Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны А/160 дугаар тушаалаар дээд боловсролын мэргэжлийн чиглэл(хөтөлбөр)-ийн нэр, индексийг шинэчлэн батлаад байна. Энэхүү тушаал гарснаар өмнө нь дээд боловсролын сургалтын

байгууллагад хэрэгжүүлж байсан хөтөлбөрийн нэр, индекстэй холбогдох тушаалууд хүчингүй болсон. Мөн энэхүү A/160 тоот тушаалаар зарим хөтөлбөр шинээр нэмэгдсэн болон хасагдсан, нэгдсэн, зарим хөтөлбөрийн нэр өөрчлөгдсөн зэрэг өөрчлөлтүүд хийгдсэн.

Эдгээр өөрчлөлтүүд нь ISCED-F 2013 олон улсын боловсролын ангилал болон олон улсын сүүлийн үеийн чиг хандлагад тулгуурлан хийгдэж буй хэдий ч цаашид хэрэгжүүлж эхлэх хөтөлбөрүүдийн тухай ойлголт юм.

1990 оноос 2021 оны хооронд их, дээд сургуульд суралцаж дээд боловсролын холбогдох зэрэг авсан төгсөгчдийн хувьд тухайн үеийн хөтөлбөрийн нэр бүхий төгсөлтийн баримт бичгийг одоогийн хэрэгжүүлж буй буюу хүчин төгөлдөр буй хөтөлбөрийн нэр, индекстэй хэрхэн дүйцүүлэн ойлгох тухай дүйцүүлэлтийн сан зайлшгүй чухал болоод байна. Ялангуяа нэр нь өөрчлөгдсөн болон хасагдсан хөтөлбөрөөр төгсөгчдийг одоогийн хүчин төгөлдөр тушаалаар хэрэгжүүлж буй аль хөтөлбөртэй дүйцүүлэн тооцож болох тухай лавлагаа шаардлагатай байна.

2. АЖЛЫН ЗОРИЛГО

Энэхүү зөвлөх үйлчилгээ нь Монгол Улсын дээд боловсролын салбарт 1990 оноос хойш батлан хэрэгжүүлж ирсэн бакалавр, магистр, докторын хөтөлбөрүүдийг одоогийн хүчин төгөлдөр мөрдөж буй сургалтын хөтөлбөрийн нэр, индекстэй хэрхэн дүйцүүлэх боломжтойг тухайн үеийн сургалтын хөтөлбөрийн агуулга болон одоогийн сургалтын хөтөлбөрийн агуулгын хувьд нийцлийн судалгаа хийсний үндсэн дээр тодорхойлох, дүйцүүлэлтийн мэдээлэлд тулгуурлан лавлагааны сан үүсгэж төгсөгч, ажил олгогч болон бусад оролцогч талуудад хүргэх зорилготой.

3. АЖЛЫН ХАМРАХ ХҮРЭЭ

Энэхүү зөвлөх үйлчилгээ нь дараах хүрээг хамарна.

- 1990 оноос хойш батлагдсан сургалтын хөтөлбөрийн нэр, индекс батлах тухай тушаалууд, хэрэгжүүлж байсан хөтөлбөрийн мэдээллийг цуглуулах;
- Хуучин болон шинэ сургалтын хөтөлбөрүүдийн агуулгад харьцуулсан судалгаа хийж боломжит дүйцлийг тодорхойлох;
- Хамаарагч талуудын саналыг авах;
- Дүйцүүлэлтийн үр дүнгийн лавлагааны цахим сан үүсгэх;

4. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Шаардлагатай тохиолдолд аливаа асуудлаар захиалагч байгууллагын удирдлагатай харилцана. Ажлын ерөнхий зорилго болон хүрээг өөрчлөхгүйгээр харилцан зөвшилцсөний үндсэн дээр энэхүү ажлын удирдамжид өөрчлөлт оруулж болно.

5. АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛД ТАВИГДАХ ШААРДЛАГА

Зөвлөх үйлчилгээний хүрээд дараах ажлыг хийж гүйцэтгэнэ. Үүнд:

- 1990 оноос хойш батлагдсан сургалтын хөтөлбөрийн нэр, индекс батлах тухай тушаалуудыг цуглуулах;

- Тухайн үеийн сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлж байсан дээд боловсролын сургалтын байгууллагуудаас хөтөлбөрийн баримт бичгийг цуглуулах;
- Хуучин болон шинэ сургалтын хөтөлбөрүүдийн агуулгад харьцуулсан судалгаа хийх;
- Дүйцүүлэлтийн боломжит хувилбарыг тодорхойлон хамаарагч талуудын саналыг тусган эцэслэж ирүүлэх;
- Дүйцүүлэлтийн үр дүнгийн лавлагааны цахим сан үүсгэж ирүүлэх;

6. ТАВИГДАХ ШААРДЛАГА

Зөвлөх үйлчилгээний багт дараах шаардлага тавигдана. Үүнд:

1. Зөвлөх үйлчилгээний багийн гишүүд нь дээд боловсролын чиглэлээр ажиллаж байсан туршлагатай байх;
2. Багийн бүрэлдэхүүнд 5-с доошгүй докторын зэрэгтэй эрдэмтэн үүнээс 1 ба түүнээс дээш гишүүн боловсролын судлалын чиглэлээр докторын зэрэгтэй байх;
3. Багийн гишүүд нь судалгааны тогтсон арга зүй, арга барилтай байх, дээд боловсролын чиглэлээр судалгаа хийж байсан туршлагатай байх;
4. Сүүлийн 3 жилд сургалтын хөтөлбөр болон хөдөлмөрийн зах зээлийн талаар судалгаа хийж байсан бол давуу тал болно.

7. ХҮЛЭЭГДЭЖ БУЙ ҮР ДҮН

Энэхүү зөвлөх үйлчилгээг хэрэгжүүлснээр дараах үр дүнд хүрсэн байна. Үүнд:

1. 1990 оноос хойш хэрэгжүүлж ирсэн дээд боловсролын салбарын сургалтын хөтөлбөрүүдийг одоогийн хүчин төгөлдөр хэрэгжиж буй сургалтын хөтөлбөрийн нэр, индекстэй онолын үндэслэлтэйгээр, оролцогч талуудын саналыг тусган дүйцүүлсэн байна.
2. Дүйцүүлэлтийн мэдээллийн лавлагааны цахим сан үүсгэсэн байна.

8. АЖЛЫН ҮРГЭЛЖЛЭХ ХУГАЦАА

Энэхүү зөвлөх үйлчилгээг 3 сарын хугацаанд хийж гүйцэтгэнэ.

№	Гүйцэтгэх ажил	Хугацаа
1	Мэдээлэл цуглуулах	Хуанлийн 15 хоног
2	Дүйцүүлэлт хийх, санал авах	Хуанлийн 30 хоног
3	Лавлагааны сан үүсгэх	Хуанлийн 15 хоног

9. ТӨСӨВТ ӨРТӨГ

Энэхүү зөвлөх үйлчилгээний төсөвт өртөг нь 65,000,000 /жаран таван сая/ төгрөг байна.

10. ТАЙЛАГНАХ

Зөвлөх үйлчилгээ гүйцэтгэгч нь даалгаврын гүйцэтгэл 50 хувь хүрмэгч гүйцэтгэлийн явцын тайланг захиалагчид танилцуулна. Эцсийн тайланг зөвлөх үйлчилгээ үзүүлэх нийт хугацаанаас хойш 14 хоногийн дотор захиалагч тал хангалттай хэмээн хүлээн авч, гүйцэтгэлийн актад гарын үсэг зурж, баталгаажуулснаар гэрээ дуусгавар болно.